



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/311

Өлгий

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/55 дугаар тушаалаар батлагдсан Нас барагчийн цогцост үхлийн шалтгаан болон өвчний онош зөв тогтоосон эсэхийг тодорхойлох эмгэг судлалын шинжилгээ хийх журмын хоёрдугаар хэсгийн 2.2.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ногооннуур сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэр "Талын толгой" гэх газарт хаваржиж байсан иргэн Төлетхан овогтой Роза, нас барсан Хиват овогтой Тилейхан нар нь халдварт өвчнөөр өвчилсөн байж болзошгүй тул нас барсан хүнд клиник, эмгэг судлалын заалтаар эмгэг антомын задлан шинжилгээ хийх, өвчтөнд хийх эмчилгээг эрчимжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	С.Айгүл	-Эрүүл мэндийн газрын дарга
Гишүүд:	Б.Батхүү	-Цагдаагийн газрын дарга
	Т.Серикжан	-Аймгийн нэгдсэн эмнэлгийн Ерөнхий эмч
	Д.Есболат	-Цагааннуур тосгоны Захирагч
Нарийн бичгийн дарга:	Б.Анаргүл	-ЗӨСТ-ийн дарга

2. Нас барсан хүнээс эмнэлзүйн болон лабораторийн шинжилгээгээр өвчний онош батлагдаагүй тул клиник, эмгэг судлалын заалтаар эмгэг антомын задлан шинжилгээ хийхийг ажлын хэсэг /С.Айгүл/-т даалгасугай.

3. Нас барсан хүнд клиник, эмгэг судлалын заалтаар эмгэг антомын задлан шинжилгээ хийх эмч нарт дэмжлэг үзүүлж ажиллахыг Цагдаагийн газар /хурандаа Б.Батхүү/-т үүрэг болгосугай.

4. Өвчтөний биеийн байдал сайжрахгүй байгаа тул эмчилгээг эрчимжүүлэх арга хэмжээ авахыг Нэгдсэн эмнэлэг /Т.Серикжан/-т даалгасугай

5. Захирамжийг хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар /дэд хурандаа Б.Анхбаяр/-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ

Ш.ХАВЫЛ



0101190640